



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 03 сарын 05 өдөр

Дугаар 69

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах зарим арга хэмжээний тухай

Хөдөө аж, ахуйн их сургуулийн 2017 оны төрийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтад хийсэн баримтын шалгалтаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 14 дүгээр зүйлийн 4, 24 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасныг зөрчиж 39.77 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг зөвшөөрөлгүй бэлтгэсэн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хөдөө аж, ахуйн их сургуулийн 2017 оны төрийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтад хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Хөдөө аж, ахуйн их сургуулийн Удирдах Зөвлөлийн дарга /Б.Энх-Амгалан/-д дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

2.1. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, шалгалтын мөрөөр зохион байгуулах ажлын төлөвлөгөө баталж, хэрэгжилтийг хангуулах;

2.2. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Хөдөө аж, ахуйн их сургуулийн захирал /Т.Хэрүүга/-д дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

3.1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах;

3.2. Тухайн жилийн үр дүн, орлого, зардлын төлөвлөгөөг эдийн засгийн тооцоо судалгаатай төлөвлөж батлуулах, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах;

3.3. Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр үндсэн хөрөнгө бэлтгэж байгааг цаашид таслан зогсоох;

3.4. Сургуулийн эзэмшлийн газрын асуудлыг шуурхай шийдвэрлэх арга хэмжээ авах, шаардлагатай тохиолдолд зөрүүтэй газар дээр хөрөнгийн үнэлгээ хийлгэн, холбогдох байгууллагад хандаж шийдвэрлүүлэх.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.


ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ГАНБАТ

ЗАХИРГАА ХУУЛЬ, ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД





Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 03 дугаар сарын 05-ний өдрийн
09 дугаар тогтоолын хавсралт

“Хөдөө аж, ахуйн их сургууль” улсын төсөвт үйлдвэрийн газрын
шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах эзэн	Үнийн дүн /Сая төгрөгөөр/	Зөрчил, дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 14 дүгээр зүйлийн 4, 24 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасныг зөрчиж үндсэн хөрөнгө зөвшөөрөлгүй олж авсан	Захирал, Санхүү, эдийн засгийн газрын дарга, холбогдох ажиллагсад	39.77	Үндсэн хөрөнгө олж авахад зөвшөөрөл авах
Зөрчил, дутагдлын нийт дүн			39.77	